



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 13 өдөр

Дугаар А/514

Чингис хот

“Урьдчилан сэргийлэх ажилд  
хөрөнгө зарцуулах тухай”

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.1.13 Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гамшгаас хамгаалах Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан Чингис хотыг бүслэн хаах 11 хөдөлгөөнт болон байнгын постонд ажиллах алба хаагчдын хоол, автомашины шатах тослоо материал бусад материалыг хавсралтаар баталсугай.

2. Урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж ажиллахад шаардагдах 7942000 төгрөгийг аймгийн Гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

Аймгийн Засаг даргын 2020 оны  
11 дугаар сарын 13 өдрийн 1/344  
дугаар захирамжийн хоёрдугаар  
хавсралт

Зардлын тооцоо

Байгууллагын нэр	Зардлын нэр төрөл					Дүн
	Бичиг хэргийн зардал	Ариутгалын зардал /11 пост, ЭМГ, ОБГ-т 9ш, /	Зарлан мэдээллийн төхөөрөмж	Шатахуун	Хоолны зардал	
Онцгой байдлын газар			150000	2544000	4,800,000	7494000
ЭМГазар	162500	285,500				448000
<b>Дүн</b>	<b>162,500</b>	<b>285,500</b>	<b>150,000</b>	<b>2,544,000</b>	<b>4,800,000</b>	<b>7942000</b>